



MCPG[®]

MONGOLIAN COPPER
PROSPECTING GROUP LLC

МОНГОЛИАН КОППЕР ПРОСПЕКТИНГ ГРУПП ХХК

Компанийн танилцуулга



КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Монголиан Коппер Проспектинг Групп ХХК нь 2021 оны 5-р сард байгуулагдсан, 100% дотоодын хөрөнгө оруулалттай компани юм. Одоогоор манай компани нь Төв аймгийн Лүн суманд “Нүхт” (XV-021860) нэртэй ашигт малтмалын хайгуулын талбай, Завхан аймгийн Баянхайрхан суманд “Оюу Толгой” (XV-021886) нэртэй ашигт малтмалын хайгуулын талбай, Дорнод аймгийн Баяндун суманд “Өндөр уул” (XV-021784) нэртэй ашигт малтмалын хайгуулын талбай, Төв аймгийн Борнуур суманд “Хөх чулуут” (XV-021833) нэртэй ашигт малтмалын хайгуулын талбай, Говь-Алтай аймгийн Бугат суманд “Алтан мандал” (XV-018239) нэртэй ашигт малтмалын хайгуулын талбай, Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд “Баянзүрх” (XV-021948) нэртэй ашигт малтмалын хайгуулын талбай дээр тус тус хайгуулын ажлыг хийж байна. Мөн Дорноговь аймгийн Иххэт суманд “Олонгийн ухаа” ордын “Их” нэртэй ашигт малтмалын ашиглалтын талбай (MV-020953) дээр олборлолт явуулахаар төлөвлөн ажиллаж байна. Бид өөрсдийн хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрлүүд дээр нүүрс, поли-металл, үнэт металл, алтны үндсэн ба шороон ордын хайгуул хийж нөөцийг тогтоож, олборлон баяжуулах зорилго тавин ажиллаж байна.

100%

ДОТООДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ КОМПАНИ



БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ



Уул уурхайн зөвлөх үйлчилгээ



Геологи хайгуулын



Олборлолтын



Боловсруулалт



ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид аюулгүй ажиллагааг эрхэмлэж, байгаль орчинд ээлтэй боловсруулах үйлдвэрлэлийг бий болгож, Монгол улсын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах зорилго тавьж ажиллаж байна.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Жил бүр сум орон нутагт 1000 ширхэгээс дээш мод тарих, тэдгээрийг арчлах



Сэргээгдэх эрчим хүчний шийдлийг нэг хэсэг болгон ашиглах



Орон нутгийн оюутнуудыг гадаад болон дотоодын их сургуулиудад сурахад дэмжлэг үзүүлэх



Усны 70-аас дээш хувийг дахин ашиглах боловсруулах үйлдвэр байгуулах. Орон нутгуудад худаг шинээр бий болгох, түүнийг арчилж хамгаалах



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Аюулгүй байдал

Эрүүл, аюулгүй ажиллах орчныг бий болгох нь компанийн үүрэг ба ажилтнуудын хариуцлага.



Оролцогч талууд

Бид харилцан хариуцлага, ил тод байдал болон оролцоог хангаснаар оролцогч талуудад нийтлэг үнэ цэнийг бий болгохыг зорьдог.



Байгаль орчны удирдлага

Төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө болзошгүй эрсдэлийг тодорхойлж, холбогдох арга хэмжээ авах замаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад идэвхи чармайлт гарган ажилладаг.

МОНГОЛ УЛС-УУЛ УУРХАЙД ТУЛГУУРЛАСАН ЭДИЙН ЗАСАГ

Хөгжиж буй уул уурхайн салбар

40,000+
уул уурхайн мэргэжилтэн

Монгол орны нийт газар нутгийн
70%
хайгуулын ажил хязгаарлагдмал
хийгдсэн

Зохицуулалт, хууль журмын дэмжлэг


5%

Алтны нөөц ашигласны
төлбөр

25%

Аж ахуйн нэгжийн
орлогын албан татвар

Уул уурхайн эдийн засагт оруулж буй хувь нэмэр



МОНГОЛ УЛС-УУЛ УУРХАЙД ТУЛГУУРЛАСАН ЭДИЙН ЗАСАГ

ОХУ, БНХАУ-ын хооронд орших хөгжиж буй ардчилсан улс

Хүн амын нягтрал бага

18

Газар нутгийн хэмжээгээр дэлхийн
18 дахь том улс

Монгол улс нь

3 САЯ

хүн амтай
(1 км квадрат газар нутагт 2 хүн)

ДНБ-ийн өсөлт

2020

6.3%

2021

8.8%

Ардчилсан
сонгуулийн

30+

жилийн түүх

Нийт хүн амын

98%

бичиг үсэг тайлагдсан

Нийт хүн амын

65%

35-аас доош насны хүмүүс
(харьцангуй залуу)

САЛБАР КОМПАНИУД



Интерконтиненталь Минералс ХХК

Тус компани нь 2021 онд байгуулагдсан, уул уурхай, уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдааны үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Одоогоор манай компани нь Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших "Өндөр уул" (XV-021784) нэртэй талбайд хайгуулын ажил, Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт байрлах "Баянзүрх" (XV-021948) нэртэй талбайд хайгуулын ажил гүйцэтгэж байна.

Хэрэгжүүлж буй төсөл
ӨНДӨР УУЛ



Талын Номт ХХК

Тус компани нь 2021 онд байгуулагдсан, уул уурхай, уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдааны үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Одоогоор манай компани нь Төв аймгийн Борнуур сумын нутагт орших "Хөх чулуут" (XV-021833) нэртэй талбайд хайгуулын ажил явуулж байна.

Хэрэгжүүлж буй төсөл
ХӨХ ЧУЛУУТ



Уянга Онги ХХК

Уянга Онги ХХК нь 2015 онд байгуулагдсан, дотоодын хөрөнгө оруулалттай уул уурхай, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг компани юм. Одоогоор манай компани нь Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших "Олонгийн ухаа" хүрэн нүүрсний ордын "Их" (XV-020953) нэртэй талбайд ашигт малтмалын олборлолтын ажил явуулж байна.

Хэрэгжүүлж буй төсөл
ОЛОНГИЙН УХАА



Их Очир Мандал Ресурс Проспектинг ХХК

2012 онд дотоодын хөрөнгө оруулалттай байгуулагдсан, уул уурхай, гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг компани юм. Одоогоор манай компани нь Говь-Алтай аймгийн Бугат сумын нутагт байрлах "Алтан мандал" (XV-018239) нэртэй ашигт малтмалын хайгуулын ажил явуулж байна.

Хэрэгжүүлж буй төсөл
АЛТАН МАНДАЛ



Зүчи Ресурсэс ХХК

Тус компани нь 2021 онд байгуулагдсан, уул уурхай, уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдааны үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Одоогоор манай компани нь Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт байрлах "Баянзүрх" (XV-021948) нэртэй талбайд хайгуулын ажил гүйцэтгэж байна.

Хэрэгжүүлж буй төсөл
БАЯНЗҮРХ

МОНГОЛИАН КОППЕР ПРОСПЕКТИНГ ГРУПП БОЛОН ХАМААРАЛ БҮХИЙ КОМПАНИУДИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСЛҮҮДИЙН БАЙРШИЛ



ОЛОНГИЙН УХАА ОРД


Эзэмшигч:
Хамаарал бүхий компани

“Их” нэртэй XV-019064 5727.97 га бүхий хайгуулын тусгай зөвшөөрлт 2017 оны 10-р сарын 17-нд Ашигт малтмал газрын тосны газрын кадастрын хэлтсийн даргын 617 тоот шийдвэрээр мөн 860.5 га (MV-020953) дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон.

Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт байрлах “Их” нэртэй хүрэн нүүрсний орд нь Улаанбаатар хотоос 447 км, аймгийн төвөөс Иххэт сум хүртэл 150 км, сумаас баруун тийш 10 км-т оршино.

ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ


Тз-ийн дугаар:	MV-020953
Нэр:	Олонгийн ухаа
Төрөл:	Хайгуулын тусгай зөвшөөрөл
Статус:	4 дэх жил
Эзэмшигч:	Уянга Онги ХХК
Талбай /га/:	860.5



Олонгийн ухаа хүрэн нүүрсний ордын байршлын зураг

2016-2017 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД

- ▶ Эрлийн маршрутын хэмжээ 12 т/км
- ▶ Соронзон хайгуул 575 т/км
- ▶ Өрөмдлөг 2148 т/м
- ▶ 1600 га талбайд топогеодезийн хэмжилтийн ажил хийсэн
- ▶ Цооногийн тоо 23
- ▶ Цооногийн каротажын хэмжилт 1593.5 т/м
- ▶ Лабораторид 220 ширхэг дээж шинжилгээнд өгсөн



Олонгийн ухаа хүрэн нүүрсний ордон геологийн зураг

2016-2017 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД



1600 га талбайд топогеодизийн хэмжилтийн ажил хийлгэсэн



Олонгийн ухаа хүрэн нүүрсний ордын ОУ-0010-р цооногт каротажийн хэмжилт хийсэн зураг

2016-2017 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД





Олонгийн ухаа хүрэн нүүрсний ордын OU-0017-р цооног 63.5-71.0 метр кернийн зураг

Д/д	Лабораторийн шинжилгээний төрөл	Нийт авсан дээжийн тоо	Шинжилгээ хийсэн лабораторийн нэр
1	Нүүрсний чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлох шинжилгээ	162	"ALS" групп ХХК-ний лаборатори
2	Нүүрсний петрографийн шинжилгээ	20	МУИС-н лаборатори /док Л. Жаргал/
3	Нүүрсний чөлөөт хөөлтийг тодорхойлох шинжилгээ	9	Геологийн Төв Лаборатори
4	Усны бүрэн шинжилгээ / цооног, нуур, худаг/	3	Геологийн Төв Лаборатори
5	Чулуулагийн физик механик шинж чанарыг тодорхойлох шинжилгээ	6	БАК-н Бетон дүүргэгч, барилгын физикийн лаборатори
6	Нүүрсний үнсний хайлах температурыг тодорхойлох шинжилгээ	3	"ALS" групп ХХК-ний лаборатори
7	Үнсэн дэх элементийн агуулга /13-элементээр/	3	"ALS" групп ХХК-ний лаборатори
8	Нүүрсний үнсний химийн найрлагыг тодорхойлох шинжилгээ	3	"ALS" групп ХХК-ний лаборатори
9	Цацраг идэвхт изотопын шинжилгээ	6	Цөмийн физикийн судалгааны төвийн лаборатори
10	Хувийн жин, Эзэлхүүн жин тодорхойлох шинжилгээ	1	Геологийн Төв Лаборатори
11	Витринитийн ойлтын зэрэг	4	Геологийн Төв Лаборатори

Олонгийн ухаа хүрэн нүүрсний ордын Их нэртэй талбайн хайгуулын ажлын үр дүнд 2016-2017 онд лабораториудад өгсөн дээжний хүснэгт


ОЛОНГИЙН УХАА ХҮРЭН НҮҮРСНИЙ ОРДЫН НӨӨЦИЙН ХЭСЭГ




Олонгийн ухаа хүрэн нүүрсний ордын дагуу зүсэлт, хайгуулын шугам X-X'

Олонгийн ухаа хүрэн нүүрсний ордын нүүрсний давхраасын бүтэц чанарын үзүүлэлтийн багана, хайгуулын шугам-III/Цооног OU-11, OU-09, OU-06, Ц-5, OU-23/

ОЛОНГИЙН УХАА ХҮРЭН НҮҮРСНИЙ ОРДЫН НӨӨЦИЙН ХЭСЭГ




Олонгийн ухаа хүрэн нүүрсний ордын Их нэртэй талбайн хэмжээнд хийсэн соронзон хайгуулын ажлын үр дүнгийн зураг



Олонгийн ухаа хүрэн нүүрсний ордын нөөцийн тооцооны дэвсгэр зураг 0-р давхраас

ОЛОНГИЙН УХАА ХҮРЭН НҮҮРСНИЙ ОРДЫН НӨӨЦИЙН ХЭСЭГ



Олонгийн ухаа хүрэн нүүрсний ордын нүүрсний давхаргуудыг зүүн өмнөөс харуулсан блок модел /Сурпак 6.3.2/

Д/д	Нүүрсний төрөл, марк	Нөөцийн блокийн дугаар ба	Зузаан,м		Эзлэхүүн жин,тн/м3		Нүүрсний нөөц мян/тн	
			Цэвэр	Бохир	Цэвэр	Бохир	Цэвэр	Бохирдолт тооцсон
Ордын дүн	Б-2	В	3.38	3.68	1.30	1.31	10659.9	11764.9
	ӨИ	С			1.30	1.31	1296.8	1508.2
	Б-2		3.14	3.57	1.30	1.31	29093.4	29625.3
	ӨИ	В+С			1.30	1.31	1296.8	1508.2
	Б-2		3.26	3.62	1.30	1.31	39753.3	41390.2
		Дүн			1.30	1.31	41050.1	42898.3
Баялаг	Р		0.00	0.00	1.30	1.31	5659.3	6057.9

Олонгийн ухаа хүрэн нүүрсний ордын Их нэртэй талбайн нийт нөөцийн хүснэгт /Нөөцийг блокийн аргаар тооцсон/



АЛТАН МАНДАЛ ТӨСӨЛ

Эзэмшигч:
Хамаарал бүхий компани

Говь-Алтай аймгийн Бугат сумын нутагт байрлах “Алтан мандал” (XV-018239) 3979.03 га хайгуулын талбай нь Улаанбаатар хотоос баруун-урд зүгт 1260 км, Говь-Алтай аймгийн төвөөс баруун тийш 223 км, Бугат сумын төвөөс баруун тийш 7 км орчим зайд оршдог. Бургастай боомтоос зүүн хойшоо 85 км-т БНХАУ-ын хилтэй ойр оршдог дэд бүтэц хөгжсөн, Баруун аймгуудыг холбосон засмал замаас чанх урагш 120 км-т оршдогоороо давуу талтай.

ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Тз-ийн дугаар:	XV-018239
Нэр:	Алтан мандал
Төрөл:	Хайгуулын тусгай зөвшөөрөл
Статус:	6 дахь жил
Эзэмшигч:	Их очир мандал ресурс проспектинг ХХК
Талбай /га/:	3979.03



Алтан мандал хайгуулын талбайн байршлын зураг Масштаб 1:1000000

2016-2021 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД



Алтан мандал талбайн геологийн зураг
масштаб 1:200000



Талбайн баруун урд хэсгийн гадаргаас
авсан чулуун дээж, дээжний дугаар
589 Cu-0.03



Эрэл зураглалын ажил
49.6 т/км

2020 ОНД ХИЙГДСЭН ГЕОХИМИЙН ДЭЭЖЛЭЛТ




Алтан мандал хайгуулын талбайн 2020 онд хийсэн геохимийн дээжлэлтийн зураг




Алтан мандал хайгуулын талбайн геохимийн дээжнүүдийг Delta-XRF спектрометр


2020 ОНД ХИЙГДСЭН ГЕОХИМИЙН АЖЛЫН ҮР ДҮН



Си-ийн хөрсний геохимийн дээжлэлтийн үр дүнгийн зураг



Алтан мандал хайгуулын талбайн 2020 онд хийсэн геохимийн дээжлэлтийн үр дүнгийн тархалтын зураг /Pb-аномал/



AZn-ийн хөрсний геохимийн дээжлэлтийн үр дүнгийн зураг


ХӨХ ЧУЛУУТ ТӨСӨЛ

Эзэмшигч:
Хамаарал бүхий компани

Төв аймгийн Борнуур сумын нутагт байрлах “Хөх чулуут” (XV-021833) төсөл 161.66 га Улаанбаатар хотоос 105 км, аймгийн төвөөс 20 км зайд оршдог. Бороогийн алтны үндсэн ордоос зүүн урагш 25 км, Зуун модны алтны үндсэн ордоос баруун зүгт 35 км, Бороо голоос зүүн зүгт 7 км-т оршино.

ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Тз-ийн дугаар:	XV-021833
Нэр:	Хөх чулуут
Төрөл:	Хайгуулын тусгай зөвшөөрөл
Статус:	1 дэх жил
Эзэмшигч:	Талын Номт ХХК
Талбай /га/:	161.66



Хөх чулуут хайгуулын талбайн геологи-ашигт малтмалын зураг

ХИЙГДСЭН АЖЛУУД



**Хөх чулуут хайгуулын талбайн
зүүн урд талын хэсэг**



**Хөх чулуут хайгуулын талбайн
зүүн хойд талын хэсэг**


НҮХТ ТӨСӨЛ

Эзэмшигч:
Монголиан Коппер Проспектинг Групп

Улаанбаатар хотоос 150 км зайд орших Төв аймгийн Лүн, Угтаалцайдам сумдын нутагт байрлах “Нүхт” (XV-021860) төсөл нь 5192.01 га талбайг хамарсан. Улаанбаатар хоттой хамгийн ойрхон орших дэд бүтэц сайн хөгжсөн талбай юм. Хайгуулын талбайд өмнө нь геологи, хайгуулын судалгааны ажил тодорхой хэмжээнд хийгдэж байснаараа давуу талтай.

ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ


Тз-ийн дугаар:	XV-021860
Нэр:	Нүхт
Төрөл:	Хайгуулын тусгай зөвшөөрөл
Статус:	1 дэх жил
Эзэмшигч:	Монголиан Коппер Проспектинг Групп
Талбай /га/:	5192.01



Бүсийн структур-металлогений бүсчлэлийг харуулсан тойм зураг (Бадарч 2002).

1992 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД


- ▶ Эрлийн маршрутын хэмжээ 239.3 т/км, үүнээс 600 га талбайд (Гялалзах, Мааньт, Бэрст) 3 хэсэгт ялгаж 1:5000 масштаб нарийвчилсан эрэл-зураглалын ажил хийсэн.
- ▶ Талбайгаас 134 ширхэг цэглэн дээж авч лабораторид өгсөн.
- ▶ Суваг малталт 1992 онд Гялалзах хэсэгт 161.5мЗ
- ▶ Өрөмдлөг 600 т/м



Нүхт хайгуулын талбайн баримт материалын зураг 1992 он

2005-2006 ОНД СЕНТЕРРА ГОУЛД МОНГОЛИА ХХК ХИЙСЭН АЖИЛ


- ▶ Эрэл зураглалын ажил 600 га талбайд хийсэн
- ▶ Геохимийн дээжлэлт 600 га талбайд масштаб 1:10000 1719 ширхэг
- ▶ Суваг малталт 420 мЗ
- ▶ Өрөмдлөг 400 т/м



Centerra Gold Mongolia ХХК 2005-2006 ондуудад гүйцэтгэсэн геологи-хайгуул, геофизикийн ажлын үр дүнгийн зураг. /600 га талбайд 1:10000 масштабтай а. Геологийн эрэл-зураглал, б. Геохимийн 1719 ширхэг дээжлэлт, боловсруулалт, в. Газрын соронзон орны зураглал, багахан талбайд цахилгаан хайгуул гүйцэтгэсэн/

2021 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД

- ▶ Эрэл зураглалын ажил масштаб 1:25000
5192 га талбайд
- ▶ Эрэл зураглалын ажил масштаб 1:5000
900 га талбайд
- ▶ Археологи болон Палеонтологийн судалгаа 5192 га талбайд хийсэн
- ▶ 600 га талбайд геофизикийн соронзон зураглалын ажил
- ▶ 600 м.куб суваг малталт
- ▶ 1657 т/м өрөмдлөгийн ажил хийсэн
- ▶ Лабораторид шинжлүүлсэн чулуун дээж 134 ширхэг
- ▶ Лабораторид шинжлүүлсэн чөмгөн дээж 1653 ширхэг



Нүхт хайгуулын талбайн геологи-ашигт малтмалын зураг, Масштаб 1:25000

2021 ОНД АВСАН ЧУЛУУН ДЭЭЖ



NUT-AR-12 чулуун дээж Au-3.41 гр/тн



NUT-CH-22 чулуун дээж Au-2.90 гр/тн

2021 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД



Нүхт хайгуулын талбайн NUTTR-01-р суваг малталтын дээжлэлт



Нүхт хайгуулын талбайн Гялалзах орчмын 10 гр/тн хүртэл алтны хүдэржилттэй кварцын судал, судланцарын бүс

2021 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД



NUKTH-01-р цооног, 31.50-39.35 м, Au-0.9 гр/тн агуулгатай кварцын судланцараар хэрчигдсэн, 2-3% пиритийн эрдэсжилттэй, хүчтэй кварц-серицитжих хувиралд автсан гранодиорит



Нүхт хайгуулын талбайн NUKTH-01-р цооног, NUTTR-02-р суваг


ОЮУ ТОЛГОЙ ТӨСӨЛ

Эзэмшигч:
Монголиан Коппер Проспектинг Групп

Улаанбаатар хотоос баруун зүгт 1190 км зайд орших Завхан аймгийн Баянхайрхан сумын нутагт байрлах “Оюу толгой” (XV-021886) 2436.13 га талбайг хамарсан хайгуулын талбай нь Монгол Улсын баруун хойд талын Баян-Тэс сумтай залгаа байрлах “Арц суурь” хилийн боомтоос 90 км-т байрладаг. Баруун аймгуудыг холбосон төв засмалаас хойд зүгт 25 км-т оршино.

ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ


Тз-ийн дугаар:	XV-021886
Нэр:	Оюу толгой
Төрөл:	Хайгуулын тусгай зөвшөөрөл
Статус:	1 дэх жил
Эзэмшигч:	Монголиан Коппер Проспектинг Групп
Талбай /га/:	2436.13



Оюу толгой хайгуулын талбайн сансарын зураг

2021 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД

- ▶ Эрлийн маршрутын хэмжээ, 50 т/км
- ▶ Талбайгаас авсан чулуун дээжийн тоо 20 ширхэг



Оюу толгой хайгуулын талбайн геологи-ашигт малтмалын зураг

2021 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД



Оюу толгой хайгуулын талбайн баруун
участикийн хэсэг



Оюу толгой хайгуулын талбайн зүүн хойд хэсгээс авсан
573-р дээж Cu -0.4%


ӨНДӨР УУЛ ТӨСӨЛ

Эзэмшигч:
Хамаарал бүхий компани

Улаанбаатар хотоос 700 км Дорнод аймгийн төвөөс 180 км зайд оршдих Баяндун сумын нутагт байрлах “Өндөр уул” (XV-021784) төсөл 1119.53 га хайгуулын талбай нь Монгол Улсын зүүн хойд талын Баян-Уул сумтай залгаа байрлах “Ульхан” хилийн боомтоос 60 км-т байрладаг. Монгол Агнуурын сутур бүс дэх алтны хүдэржилтийн тархалтын хэсэгт оршдог. Хайгуулын талбай нь маш том алтны шороон ордын эхэнд байрладаг Алтны хүдэржилт нь Цагаанчулуутын интрузив цогцолбортой холбоотой Өндөр уулын хайгуулын талбайд Цагаанчулуутын интрузив комплекс тархсан байдаг. Өндөр уулын алтны төсөл нь Цагаанчулуутын (ЦЧ) алтны ордоос хойш 3 км зайд оршдог. Ордын нөөц 2013 он: 10,8 тонн

ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ


Тз-ийн дугаар:	XV-021784
Нэр:	Өндөр уул
Төрөл:	Хайгуулын тусгай зөвшөөрөл
Статус:	1 дэх жил
Эзэмшигч:	Интерконтиненталь Минералс ХХК
Талбай /га/:	1119.53



Өндөр-Уул хайгуулын талбайн ашигт малтмалын зураг


2021 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД

- ▶ Эрлийн маршрутын хэмжээ 136 т/км
- ▶ Эрлийн ажлын чулуун дээж 23 ширхэг
- ▶ Геохимийн сорьцолт 24 ширхэг
- ▶ Соронзон хайгуулын ажил 260 т/км




Өндөр-Уул хайгуулын талбайн хүнцэл, алтны хөрсний геохимийн гажил, чулуун дээжний үр дүнг сансарын болон геологийн зураг дээр харуулсан байдал

2021 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД



Хүнцэл, алтны хөрсний геохимийн гажил, чулуун дээжний үр дүнг газрын соронзон орны эрчимжилтийн зураг дээр харуулсан байдал



Монгол Агнуурын сутур бүс дэх алтны хүдэржилтийн тархалтын зураг

2021 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД



Өндөр-Уул хайгуулын талбайн зүүн хойноос харагдах байдал /Цагаанчулуут хоолойн алтны шороон орд/



Өндөр-Уул хайгуулын талбайн өмнөд хэсгээс Цагаанчулуут худаг алтны шороон болон үндсэн ордуудын харагдах байдал

2021 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД



Өндөр-Уул хайгуулын талбайн өмнөд хэсгээс авсан чулуун дээжнүүд



Oxidized pyrite, galenite, anglesite, malachite and scorodite mineralized quartz-sulfide vein.
Au-0.5-11.2g/t,
Ag-7-677g/t,
(average: Au-4.04g/t,
Ag-182g.t)



Өндөр-Уул хайгуулын талбайн зүүн өмнөд хэсгээс авсан чулуун дээжнүүд


БАЯНЗҮРХ ТӨСӨЛ

Эзэмшигч:
Хамаарал бүхий компани

Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт байрлах вольфрам агуулсан “Баянзүрх” (XV-021948) 4718.45 га хайгуулын талбай нь Улаанбаатар хотоос баруун зүгт 1350 км, Баян-Өлгий аймгийн төвөөс баруун урд 110 км, Цэнгэл сумын төвөөс баруун урагшаа 35 км орчим зайд оршдог. Ховд гол вольфрамитын ордтой хил залгаа баруун талд, Цэнгэл сумын Цагаан нуур боомтоос зүүн зүгт 70 км, Алтай сумын Даянгийн боомтоос хойд зүгт 75 км-т оршдоггоороо давуу талтай.

ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Тз-ийн дугаар:	XV-021948
Нэр:	Баянзүрх
Төрөл:	Хайгуулын тусгай зөвшөөрөл
Статус:	1 дэх жил
Эзэмшигч:	Зүчи Ресурсэс ХХК
Талбай /га/:	4718.45



Баянзүрх хайгуулын талбайн геологи-ашигт малтмалын зураг

2021 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД

- ▶ Эрлийн маршрутын хэмжээ 15 т/км
- ▶ Талбайгаас авсан чулуун дээжийн тоо 9 ширхэг



Баянзүрх хайгуулын талбайн баруун хэсгийн зураг

2021 ОНД ХИЙГДСЭН АЖЛУУД



Баянзүрх хайгуулын талбайн баруун урд хэсгийн вольфрам, бага зэрэг зэсийн хүдэржилттэй кварцын судал, судланцараар хэрчигдсэн цахиржсан бүсийн зураг



Баянзүрх хайгуулын талбайн баруун хэсгээс авсан 580-р дээжний зураг W-0.2%



Баянзүрх хайгуулын талбайн зүүн урд хэсэгт хил залгаа орших Ховд гол вольфрамитын ордын дээж

ХОЛБОО БАРИХ



Компанийн хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 15-р хороо "Режис плэйс" 5 давхар 503 тоот

Утас: (+976) 7000-7757
И-мэйл: info@mcpг.mn

Геологич:

Б. Энх-Амгалан
Утас: (+976) 9509-9284
И-мэйл: enkh-amgalan@mcpг.mn

